

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНААС 2009 ОНЫ 01 ДҮГЭЭР САРД
ХИЙСЭН ГОЛ АЖИЛ**

Нэг. Бодлого төлөвлөлтийн асуудлаар:

1. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал:

- “Атрын гурав дахь аян” – тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцүүлж, Засгийн газрын 12 дугаар тогтоол гаргуулав.
- Мал өвөлжилтийн байдал зарим аймагт хүндэрч байгаатай холбогдуулан “Улсын нөөцөөс өвс, тэжээл хөнгөлөлттэй үнээр олгож, нөхөн бүрдүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцүүлэн, Баян-Өлгий, Ховд, Завхан, Баянхонгор, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн малчдад улсын нөөцөөс 5000 тонн өвс, 4000 тонн тэжээлийг хөнгөлөлттэй үнээр олгохоор шийдвэрлүүлэв.
- “Орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэл” бодлогын баримт бичгийн төслийг УИХ-ын Жижиг, дунд үйлдвэрийн дэд хороонд танилцуулж, “Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил”-ийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн хуралдаанд танилцуулахад бэлэн болгов.

2. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал:

- “Малчдын талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичгийн төслийг хэлэлцүүлж,
- ХХААХҮЯ-наас 2009 – 2012 онд баримтлах үндсэн чиглэл,
- Яамны шинэчлэн зохион байгуулсан стратеги, бүтэц, бүрэлдэхүүний талаар танилцуулав.

3. Судалж, боловсруулсан асуудлын талаар:

- “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төсөл, “Жижиг дунд үйлдвэрийн хөтөлбөрийн Үндэсний зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүн батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.
- “Монгол Улсыг хөгжүүлэх сангаас хөрөнгө гаргах тухай” хуулийн хэрэгжилтийн танилцуулгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.
- “Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, “Улсын тэргүүний тариаланч” шалгаруулах болзолд ирүүлсэн материалуудыг нэгтгэж, дүнг Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулахад бэлэн болгов.
- “Алтан төлийн эзэн” шалгаруулах болзол, “Зохиомол хээлтүүлгийн техникч нарыг шалгаруулах” журмын төслийг боловсруулав.
- Импортлоор оруулж байгаа хүнсний улаан буудай болон гурилын гаалийн татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай санал боловсруулж, Гаалийн тарифын зөвлөлд хүргүүлэв.
- “Хүнсний хангамж, аюулгүй байдал, шим тэжээллэг чанар” үндэсний хөтөлбөрийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.
- ХХААХҮ-ийн сайдын 2009 оны төсвийн багцад батлагдсан хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж эхлээд байна. Дор дурдсан тендерийн баримт бичгийг боловсруулав. Үүнд:
 - Услалтын системийг шинээр барих, сэргээн засварлах ажлын зураг төсөл шалгаруулах,
 - Үйлдвэрлэл, технологийн паркийн захиргаа, бизнес инкубаторуудын барилгыг худалдан авах, үйлдвэрлэл, технологийн паркийн судалгааны ажил хийлгэх, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах,
 - Таримал ургамлын үр ариутгах фунгицид худалдан авах,

- “Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн арга хэмжээнд шаардагдах хүлэмж худалдан авах,
- “Халх голын бүс нутагт хөдөө аж ахуйг сэргээн хөгжүүлэх мастер төлөвлөгөөний төсөл”-ийн хүрээнд баригдах загвар аж ахуйн захиргааны байр, агуулахын барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах,
- Үрийн буудай худалдан авах.

Хоёр. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудлаар:

- ХХААХҮ-ийн салбарын удирдах ажилтны зөвлөлгөөнийг 02 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг хангаж байна.
- Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны харьяа отрын малыг эрсдлээс хамгаалах тэжээлийн нөөц бүрдүүлэх үүрэгтэй Төв аймгийн Баянчандмань, Жаргалант сумуудад ажилладаг бага оврын 2 тэжээлийн цехийн үйлдвэрлэлийн ажлын жигд, хэвийн ажиллагааг хангаж, нийт 100 тонн багсармал тэжээл үйлдвэрлэж, нөөцлөөд байна.
- Аймаг дундын отрын бүс нутагт 529 өрхийн 349.5 мянган мал отроор өвөлжиж байгаа бөгөөд малын зүй бус хорогдлоос сэргийлэх зорилгоор Завханмандал, Ургамал, Дөрвөлжин сумдын 60 өрхөд 8 тонн тэжээл зээлээр олгож, Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улааны отрын бүс нутагт 10 тонн, Завхан аймгийн Завханмандал сум дахь Багахайрханы отрын бүс нутагт 17 тонн багсармал тэжээл хүргүүлэв.
Мөн Говь-Алтай аймгийн Аргалантын отрын бүсэд байгаа 35 өрхөд хүн эмнэлэг, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлж, нийт 42.0 мянган төгрөгийн эмээр хангаж, 8000 малд хамуу өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийлгэв.
Аймаг дундын отрын бүс нутагт инженерийн хийцтэй 24, энгийн уурхайн 14 худаг ажиллуулж, усан хангамжийн асуудлыг шийдвэрлэж байна.
- ОХУ-аас импортоор оруулж ирсэн улаан буудайнаас 5060 тонныг иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн гэрээ байгуулж олгоод байна.
- “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлын хэсэг, ажлын төлөвлөгөө батлуулан, бэлтгэл ажлыг хангаж байна.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн Ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд байгуулсан 2008 онд бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг дүгнэв.
- Цөм сүргийн үржлийн төвүүдтэй 2008 онд хийсэн үр дүнгийн гэрээний биелэлт, Төвүүдийн санхүүгийн тайланг хүлээн авч, дүгнэлт мэдээлэл гаргав. 2008 онд Улаанбаатар Дархан-Уул, Орхон, Төв, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод, Өвөрхангай, Баян-Өлгий, Хөвсгөл зэрэг аймаг, хотод 36 зохиомол хээлтүүлгийн салбар ажиллаж, 8158 тун үрээр 3138 үнээг махны үхрийн үрээр хээлтүүлж, дунджаар 83.5%-иар хээл авахуулж, богийн зохиомол хээлтүүлгийг “Баяд”, “Дархад”, “Дорсет”, “Суффолк” хуцны гүн хөлдөөсөн 3510 тун үрээр Төв, Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Улаанбаатар хотын 38 салбарт 1350 эм хонийг, “Эрчмийн хар”, “Баяндэлгэрийн улаан” ухны 2600 тун үрээр 1000 эм ямаа, импортоор ирсэн сүүний ямааны ухны үрээр 310 эм ямааг, арвин ашиг шимт “Хангай”, “Ерөө”, “Орхон”, “Алтанбулаг”, “Үзэмчин”, “Сартуул” үүлдэр, үүлдрийн хэсгийн хуцнаас үр авч 5908 эм хонинд хээлтүүлэг хийж, нийт 8586 бог малыг зохиомлоор хээлтүүлж, 14268 тун үр ашигласан байна.
- Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэр болон төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2009 онд зохион байгуулах хурал, зөвлөлгөөн, семинар, үзүүлэх сургууль зэрэг нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулав.
- Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа, үйлчилгээний газруудын судалгааг гаргаж, нийслэл, дүүргийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн ажилтнуудтай уулзалт зохион байгуулав.
- Монгол Улсыг хөгжүүлэх сангийн нөөц хэлбэрээр байршуулсан хүнсний улаан буудайн нөөцийн хадгалалт, чанар, тоо хэмжээнд нь хяналт тавих асуудлаар СЯ, УМХГ-тай хамтарсан ажлын хэсэг ТЭДС-ийн харьяа Хөтөл, Сэлэнгэ, Хархорин салбаруудад ажиллаж байна.

Гурав. Гадаад хамтын ажиллагаа болон дотоод ажлын талаар

- Монгол Улсын Ерөнхий сайдын ОХУ-д хийсэн айлчлалын үеэр Монгол Улсын ХХААХҮЯ, ОХУ-ын ХААЯ хооронд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай Протокол болон Монгол Улсын ХХААХҮЯ, ОХУ-ын Эрхүү хотын ХААИС-ийн хооронд хамтран ажиллах “Санамж бичиг”-т гарын үсэг зурав.
- “Атрын гурав дахь аян” – тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд хөдөө аж ахуйн машин, техникийн шинэчлэлд АНУ-ын “Жон Дир” компанийн бүтээгдэхүүнийг АНУ-ын хөнгөлөлттэй зээлээр авах боломж, нөхцөлийг судлан хэрэгжилтийг зохион байгуулах асуудлаар ХХААХҮ-ийн сайд Т.Бадамжунай АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Марк К. Минтонтой хийсэн уулзалтыг зохион байгуулав.
- Японы “ЖАЙКА” байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй “Мал аж ахуй, газар тариалангийн хосолсон загвар аж ахуйн хөгжлийг дэмжих төсөл”-ийн ажлын хэсэгт орж ажиллах Монголын талын ажилтныг томилуулж, төслийн хэрэгжилтийг зохион байгуулж байна.
- БНСУ-ын “КОЙКА” байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй “Халх голын мастер төлөвлөгөөний төсөл”-ийн хүрээнд ажиллах дотоодын зөвлөхүүдийг сонгох ажлыг зохион байгуулав.
- ХБНГУ-д зохион байгуулагдсан “Ногоон долоо хоног” Олон улсын үзэсгэлэнд дэд сайд Ж.Саулег оролцуулж, тайланг холбогдох газар, хэлтэст танилцуулав.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2008 оны онцлох үр дүнг нэгтгэн гаргаж, МҮОНТВ-ийн “ММ” агентлаг болон арилжааны телевизүүд, Монголын радио, өдөр тутмын “Үнэн”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ” зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд сурталчлах ажлыг охион байгуулав.
- ХХААХҮЯ-ны 2008 оны үйл ажиллагааны нэгдсэн тайланг гаргаж, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.
- Яамны газар, хэлтэс, харьяа байгууллагын дарга нар болон яамны төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчилэн баталгаажуулав.
- ХХААХҮЯ-ыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын сүлжээний төвтэй шилэн кабелиар холбож, интернэт дамжуулах хурдыг сайжруулав.
- Яамны вэб сайтад шинэчилэн батлагдсан бүтэц, зохион байгуулалт, яам, газар, хэлтэсийн чиг үүргийн талаарх мэдээг өөрчлөн, баяжуулав.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ